

## ХУРАЛДААНЫ ТОЙМ

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2015 ОНЫ АРВАН ЕСДҮГЭЭР ХУРАЛДААН

Хуралдаан 2015 оны тавдугаар сарын 28-ны 14 цаг 05 минутад эхэлж, 15 цаг 50 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 46 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргуулах тухай	Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 5 дугаар сарын 28-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн: 1. Баатархүүгийн Батсэлэнгийг Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх 2. Нөөцөд бүртгэгдсэн иргэн Баатархүүгийн Батсэлэнгийг Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Санхүүгийн зохицуулах хорооны дарга З.Нарантуяад санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
2	Төв аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргуулах тухай	Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 5 дугаар

		<p>сарын 28-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Дагвадоржийн Батбаярыг Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх</p> <p>2. Нөөцөд бүртгэгдсэн иргэн Дагвадоржийн Батбаярыг Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга Д.Мэндсайханд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>Архангай, Баянхонгор, Сэлэнгэ аймгийн нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2015 оны 05 дугаар сарын 11-16-ны өдрүүдэд Архангай аймаг, Баянхонгор аймаг, Сэлэнгэ аймагт зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Архангай аймаг, Баянхонгор аймаг, Сэлэнгэ аймагт 2015 оны 05 дугаар сарын 11-16-ны өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1, 2, 3 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 52 иргэн /Архангай аймагт 22, Баянхонгор аймагт 10, Сэлэнгэ аймагт 20/-ийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ</p>

		<p>албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 4, 5, 6 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 51 иргэн /Архангай аймагт 6, Баянхонгор аймагт 15, Сэлэнгэ аймагт 30/-ийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 7, 8, 9 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 12 иргэн /Архангай аймагт 1, Баянхонгор аймагт 3, Сэлэнгэ аймагт 8/-ийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 10, 11, 12 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 13 иргэн /Архангай аймагт 1, Баянхонгор аймагт 5, Сэлэнгэ аймагт 7/-ийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар тус тус нэр дэвшүүлэх</p> <p>3. Энэхүү тогтоолын 7-12 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 25 нэр дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг дахь салбар зөвлөл /Б.Лхагвасүрэн/-д, Төрийн албаны зөвлөлийн Баянхонгор аймаг дахь салбар зөвлөл /О.Тойвгоо/-д, Төрийн албаны зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл /Ө.Сувдаа/-д тус тус үүрэг болгох</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол</p>
--	--	--

		гаргахаар тогтов.
4	Төрийн албаны зөвлөлийн Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.2, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг”-ийг баримтлан, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын “Хоёр”-ын 2-т “Төрийн албаны зөвлөлийн Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг дараах байдлаар өөрчлөх. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга;</li> <li>2. Дэд дарга;</li> <li>3. Дэд дарга;</li> <li>4. Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга;</li> <li>5. Эрсдлийн удирдлага, стратеги төлөвлөлтийн газрын дарга;</li> <li>6. Хууль, эрх зүй, хүний нөөцийн хэлтсийн дарга;</li> <li>7. Захиргаа, санхүү аж ахуйн хэлтсийн дарга;</li> <li>8. Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн;</li> <li>9. Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн</li> </ol> <p>тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
5	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гаалийн ерөнхий газарт Төрийн	Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3, 35 дугаар зүйлийн 35.1.2,

<p>албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянан шалгасан Ажлын хэсгийн дүнгийн тухай</p>	<p>39 дүгээр зүйлийн 39.5 дахь заалтуудыг баримтлан Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>”Ажлаас чөлөөлж, ажилд томилох тухай” Гаалийн ерөнхий газрын даргын 2015 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн Б/102 дугаар тушаалаар Гаалийн ерөнхий газрын Хууль эрх зүйн газрын даргын албан тушаалаас Чимэдийн Энхээг чөлөөлсөн хэсгийг 2015 оны 5 дугаар сарын 28-ны өдрөөр тасалбар болгон хүчингүй болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар Гаалийн ерөнхий газарт Төрийн албаны тухай хэрэгжилтийг шалгасан ажлын хэсгийн дүнг хэлэлцээд, Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.3, 35.1.14, “<i>ᠤᠯᠤᠰ ᠶᠡᠬᠡ Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны зөвлөлийн дүрмийн 4.3.4 дэх заалтуудыг баримтлан шийдвэрийг үндэслэн:</i></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гаалийн ерөнхий газарт төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, гарсан зөрчил дутагдлыг арилгаж ажиллах талаар тодорхой хугацаатай үүрэг даалгавар өгөх</li> <li>2. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гаалийн ерөнхий газрын даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалт, санал дүгнэлт гаргах, нэр дэвшүүлэхийг Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.2, 4.2.4, 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын тухай хуулийн 18<sup>3</sup> дугаар зүйлийн 2, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар</li> </ol>
---	--

		<p>тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журмын 9-ийн "а"-д тус тус заасны дагуу хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулахыг Монгол Улсын Засгийн газарт зөвлөх:</p> <p>3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавихыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба /С.Цэндэндамба/-д даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
6	<p>Бусад асуудал:/Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай /</p>	<p>Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирүүлснийг хэлэлцээд, уг ажлын байранд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулахаар шийдвэрлэлээ.</p>